

А Археологийн материал болох шавар болон вааран эдлэлийн тухай

(1) Газар доорх шавар болон вааран эдлэлийг олдворлох нь:

Археологийн үүднээс шинжилгээ, судалгаа хийдэг эртний туурь болон эд өлгийн зүйлүүд нь булш бунхан гэх мэтгэй адил одоо ч гэсэн газрын хөрсөн дээр шууд харагдах боломжтой зүйлүүд байдаг ч, ихэнх нь малталт судалгаагаар газрын хөрсөн доороос олддог. Шороо нь ерөнхийдөө газрын хөрсөнд дээр дээрээсээ давхарласан тогтоцтой байна. Үүнийг хөрсний давхарга гэдэг. Хөрсний давхарга нь дээр дээрээсээ давхарласан байдалтай байх тул “холилдолгүй давхарласан газрын давхраа”ны тухайд бол дээр байгаа хөрсний давхарга нь доор байгаа хөрсний давхаргыг бодвол шинэ юм. Малталт судалгаагаар дээр дээрээсээ давхарласан хөрсний давхаргаас олдворлосон шавар болон вааран эдлэлийг тус тусад нь ялган авснаар тухайн олдворын хаягдсан он тооллыг тогтоож болдог.

(2) Малталт судалгаагаар олдворлосон шавар болон вааран эдлэлийг ангилах нь:


Нэг удаагийн малталт судалгаагаар олдворлосон их хэмжээний шавар болон вааран эдлэлийг нэг бүрчлэн мэдээлэх нь боломжгүй зүйл юм. Ийм бэрхшээлтэй нөхцөлөөс гарах эхний алхам бол ангилалт хийх явдал юм. Тухайн шавар болон вааран эдлэлийн хэлбэр, шаврын чанар, хэмжээ, хээ зэргийн ижил болон ялгаатай талаар нь хэд хэдэн бүлэгт хувааж, бүлэг тус бүрийг дугаарлана.

Ийнхүү хуваагдаж нэг бүлэгт багтсан тус материалууд нь хоорондоо ижил төстэй талууд байвч яв цав адил гэсэн үг биш юм. Иймд материал тус бүр дэх олон тооны элементийн дотроос шаардлагатай гэсэн элементийг түүн авч бүрдүүлсэн зүйлийг “загвар” гэнэ. “Загвар” гаргахад хамгийн тохиромжтой материалын нөхцөл нь: материалын тоо олон байх, богино хугацаанд хаягдсан зүйл байх хэрэгтэй ба үүнийг нэг багц материал гэж нэрлэнэ.

“Загвар”-г тогтсон зарчимд тулгуурлан хийдэг судалгааг “хэлбэр судлал” гэнэ. Археологийн материалыг “хэлбэр судлал”-р ангилахад хамгийн үндсэн элемент болдог зүйл нь “үүрэг”, “цаг хугацаа”, “орон зай” зэрэг юм.

(3) Малталт судалгаагаар олдсон шавар болон вааран олдворыг археологийн үүднээс шинжлэх нь:

Шавар болон вааран олдворыг ангилан жагсаахад хамгийн чухал элемент бол “орон зай” юм. Явцуу хүрээнд хэлбэл “загвар”-г “цаг хугацаа”-нд тулгуурлан ангилан гаргасан олон тооны “загвар”-г нэгтгэж тухайн



Гал, чийдэнгийн түүх болон тархац

олдворын “он тоолол”-г тодруулдаг. Тухайн олдворын “он тоолол” нь аль бүс нутгагт хамаарахыг тодруулж өгдөг ба тухайн бүс нутгаас хичнээн алслагдсан туурь байсан ч цаг хугацааны хувьд нэг он тоололд багтах юм. Эртний хүмүүсийн аж амьдралыг туурийн бүтцээс тааварлах боломжтой бөгөөд ингэхэд үндсэн чиглүүлэгч болдог зүйл нь олдворын “он тоолол” юм.

Өргөн уудам нутаг дэвсгэр бүхий бүс нутгийн тухайд олдворын материалын нөхцөл байдалд бүс нутгийн ялгаатай харагддаг. Тэгвэл ямар ялгааг нь гаргаж, ялгааг нь яаж тогтоож мэдэх вэ? Бүс нутгуудыг хооронд нь харьцуулсанаар тухайн шавар болон вааран эдлэлийн үйлдвэрлэл болон гүйлгээ ямар хэмжээтэй байсныг мэдэх боломжтой. Түүнчлэн тухайн үеийн улс төр болон эдийн засгийн байдлыг ч мэдэх боломжтой юм.

Зургийн тайлбарыг доороос үзнэ үү:

1. Хүрэл толин дээрх цагаан барны хээний өөрчлөлт.
2. Он тооллын ялгаа нь бүс нутгийн ялгаа болж үлдсэн.